



## Шинжээчийн тайлан

**Байгууллагын нэр:** Монгол улсын их сургуулийн Шинжлэх ухааны сургууль

**Хөтөлбөрийн нэр:** Гадаад хэлний орчуулга (япон хэл)

**Индекс:** D023101

**Шинжээчийн баг:**

**Ахлагч:**

У.Мягмаржав- Боловсролын хүрээлэнгийн Бакалаврын боловсролын агуулга, хөтөлбөрийн судалгаа хариуцсан эрдэм шинжилгээний дэд ажилтан

**Гишүүд:**

Б.Булган- Монгол Улсын боловсролын их сургуулийн Багшийн сургуулийн хөтөлбөрийн албаны дарга

С.Батдулам- Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Судалгаа хөгжил хариуцсан ахлах мэргэжилтэн

Б.Батсайхан- Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Гадаад хэлний тэнхмийн ахлах багш

Он сар өдөр: 2021.12.17

## Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

## Товчилсон үгийн тайлбар

Монгол үгс

БЦ - Багц цаг

БМИҮЗ - Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл

БСШУСЯ - Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

БСШУЯ - Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам

БШУЯ - Боловсрол Шинжлэх Ухааны Яам

ЗХШҮА - Захиргаа, хяналт шинжилгээ, үнэлгээний алба

КОНА - Номын сангийн автоматжуулсан программ

МУИС - Монгол Улсын Их Сургууль

МЯХБХ - Монголын япон хэлний багш нарын холбоо

ХЧБХ - Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс

ӨҮТ - Өөрийн үнэлгээний тайлан

ШУС - Шинжлэх ухааны сургууль

ХУС - Хүмүүнлэгийн ухааны салбар

ЭСЯ - Элчин сайдын яам

ЯХБС - Япон хэлний боловсролын стандарт

ЕОХСХ- Европын олон хэлний суурь хөтөлбөр

## Гадаад үгс

CDIO - Conceive Design Implement Operate

JCR - Импакт фактор бүхий олон улсын мэргэжлийн сэтгүүл

SiSi - МУИС-ийн Сиси сургалтын мэдээллийн систем

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Монгол улсын их сургуулийн Шинжлэх ухааны сургууль School of Arts and Sciences, National University of Mongolia /NUM/	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Гадаад хэлний орчуулга (япон хэл)	
Индекс	D023101	
Шинжээчид	Ахлагч: У.Мягмаржав Гишүүд: Б.Булган С.Батдулам Б.Батсайхан	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Боловсролын магадлан итгэмжлэх Үндэсний зөвлөлийн мэргэжилтэн Н.Түмэнжаргал	
Төлөвлөгөө	Хугацаа	Үйл ажиллагаа
	2021-12-09 Пүрэв	
	09:00-10:00	Шинжээчийн багийг танилцуулна. Магадлан итгэмжлэлийн үйл явц, хуваарийг танилцуулах Удирдлага болон Өөрийн үнэлгээний багтай уулзах: Сургуулийн бэлдсэн хөтөлбөрийн товч танилцуулга /тайлан бичсэнээс хойшхи мэдээллийг оруулах/
	10:00-11:00	Сургуулийн орчин нөхцөл, лаборатори, анги танхим, номын сантай танилцах
	11:00-13:00	Сургуулийн бэлтгэсэн илрэл нотолгоотой танилцах
	13:00-14:00	Өдрийн завсарлага
	14:00-15:00	Оюутнуудтай хийх уулзалт /цахим/
	15:00-16:00	Төгсөгчидтэй хийх уулзалт /цахим/
	16:00-17:00	Сургуулийн бэлтгэсэн илрэл нотолгоотой танилцах
	2021-12-10 Баасан	
	09:00-10:00	Шинжээчийн багийн уулзалт
	10:00-11:00	Ажил олгогчидтой хийх уулзалт /цахим/
	11:00-12:00	Багш нартай хийх уулзалт
	12:00-13:00	Сургуулийн бэлтгэсэн илрэл нотолгоотой танилцах
	13:00-14:00	Өдрийн завсарлага
	14:00-16:00	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах
	16:00-17:00	Шинжээчийн баг магадлан итгэмжлэлийн эцсийн шийдвэрийг бус, урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэх

Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-өөс эрхлэн мөрдүүлж буй Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд мөрдөх заавар, журмууд, БШУ-ны Сайдын 2014 оны А/174 тоот тушаал, БСШУ-ны Сайдын 2017 оны А/52 тушаал, 2020 оны А/308 тоот тушаал, БМИҮЗ-ийн Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайлан, Шинжээчийн үнэлгээний тайлан болон холбогдох бусад заавар, эрхийн баримт бичиг, БМИҮЗ-ийн Захирлын 2021 оны 11 сарын 16-ны өдрийн А/133 тушаал.
---------------------------	--

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

### Мэргэжилтэн бэлтгэж ирсэн түүх

Монгол улсад МУИС-д анх япон хэлтэй боловсон хүчин бэлтгэж ирсэн түүхтэй. БНМАУ-ын СнЗ-ийн улсын дээд тусгай мэргэжлийн дунд боловсролын хорооны даргын 1975 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 26 тоот “нууц” тушаалаар МУИС-ийн Хэл Бичгийн Факультетад Япон хэлийг сонгоноор заах болж, монгол хэлний салбарын 3-р ангиас 6 оюутан элсүүлэн хичээллэж эхэлснээр япон хэлтэй мэргэжилтэн бэлтгэх алхам тавигджээ. 1977 онд япон хэлний сонгон ангийн анхны төгсөлт болж, үндэсний япон хэлтэй боловсон хүчин бэлтгэгдсэн байна.

1990 оноос хойш Япон орныг сонирхох, япон хэл сурах эрмэлзэл илт нэмэгдэж, нийгмийн шаардлага, элсэгчдийн эрэлт хэрэгцээ зэргээс үүдэж, 1990 онд Хэл Бичгийн Факультетад япон хэлний ангийг 10 оюутантай нээжээ. ОУХДС-ийн зөвлөлийн 1993 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн өргөтгөсөн хурлаар тус сургуулийн бүтцийг оновчтой болгох санал гарсны дагуу МУИС-ийн захирлын 1993 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 758 тоот тушаалаар 1993 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс Япон Судлалын тэнхим байгуулагдсан. 2014 онд МУИС-ийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр МУИС-д япон хэлний сургалт явуулж байсан МХСС-ийн гадаад хэлний тэнхимийн япон хэлний салбар, ОУХНУС-ийн дипломат орчуулгын тэнхимүүдийн япон хэлний салбарыг нэгтгэж, Ази Судлалын Тэнхимийн Япон хэлний салбар болон ажиллаж байна.

Бакалаврын сургалтын төлөвлөгөө, сургалтын стандартын өөрчлөлтийн дагуу 1991-2000 онд япон хэлээр мэргэжсэн гадаад албаны мэргэжилтэн, 2006 оноос япон хэл судлал, орон судлал, 2015 оноос гадаад хэлний орчуулга (япон) чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байна.

### Хөтөлбөрийн боловсролын зорилго, чиглэл, онцлог

Гадаад дотоодын ихэнх их дээд сургуульд япон хэлний орчуулагч мэргэжилтнийг бэлтгэх хөтөлбөр нь хүмүүнлэгийн ухааны салбарт багтах бөгөөд хэлний үндсэн мэдлэг дээр тулгуурлан хэл шинжлэл, соёл, сэтгэлгээ, орчуулгын онол арга зүйн мэдлэг олгоход илүүтэй анхаарсан байна. Түүнчлэн Монгол улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 3 дугаар сарын 13-ны өдөр баталсан “Мэргэжлийн индекс шинэчлэн батлах А-78 тушаалаар урлаг, хүмүүнлэгийн хэсгийн хэл төрөлжсөн чиглэлд оруулсан байдаг.

МУИС-д 1975-1990 оныг хүртэл сонгон хэлбэрээр япон хэлний багш-орчуулагч, 1990 оноос япон хэлний багш-орчуулагч, 1991-2005 онд япон хэлний багш-орчуулагчийн мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэж ирсэн.

“Гадаад хэлний орчуулга (Япон хэл)” хөтөлбөрийн зорилго нь “эх хэл болон гадаад хэлний нийгэм-соёлын ялгааг ойлгож, зөв дамжуулж чадах орчин үеийн чиг хандлагад нийцсэн гадаад хэлний мэдлэгтэй, мэргэжлийн ёс зүйтэй мэргэжилтэн бэлтгэх бөгөөд эл зорилгын хүрээнд өрнө, дорнын түүх, нийгэм, соёл, сэтгэлгээний тухай суурь мэдлэгтэй, орчуулга, хэлмэрчлэхүйн үндсэн мэдлэг, чадвар, зөв хандлагатай төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллага, аялал жуулчлал, боловсролын байгууллагад ажиллах чадвартай мэргэжилтэн бэлтгэх зорилт тавин ажиллаж байна.

“Гадаад хэлний орчуулга (Япон хэл)” хөтөлбөрийн үндэслэл, зорилго, зорилт нь сургалтын хөтөлбөрүүдийг дэлхийн тэргүүлэх түвшинд хүргэж, оюутанд өргөн сонголтыг бий болгох МУИС-ийн тэргүүлэх зорилтод хүрч, олон улсын жишиг, өнөөгийн нийгмийн шаардлага, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ зэргээс шалтгаалан хөрвөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх сургуулийн эрхэм зорилго, зорилттой нягт уялдаж байгаа болно.

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч баг хамт олон нь судалгааны хамрах хүрээгээ өргөжүүлж, дэлхийн жишигт нийцүүлэх МУИС-ийн стратегийн нэг тэргүүлэх чиглэлийн хүрээнд, хэл орон судлал, орчуулга, хэл шинжлэлийн салбарт онолын болон хавсарга судалгааг чанартай хийж, боловсролын чанарыг тогтвортой дээшлүүлэн, сургалт-эрдэм шинжилгээний ажлаараа үндэсний хэмжээнд тэргүүлэх төв байж, хөрвөх чадвартай оюутан суралцагчдыг бэлтгэн гаргаж, нийгэмд чанартай үйлчилгээ үзүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Дээр заасан хөтөлбөрийн зорилгод уялдуулан МУИС-ийн сургалтын журамд нийцүүлэн мэргэжлийн хөтөлбөрөөр төгсөгчдийн компетенц (мэдлэг, чадвар, хандлага), хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхойлж, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрүүдийг боловсруулсан. Тус хөтөлбөр нь 2013 онд Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр магадлан итгэмжлэгдсэн болно.

### **Хөтөлбөрийн чиглэлээр эрдэм шинжилгээний бүтээл**

2015-2020 оны хичээлийн жилд Ази судлалын тэнхимийн япон судлалын багш нар нийт 51 өгүүлэл/давхардсан тоогоор/ хэвлүүлснээс гадаадын сэтгүүлд 17 өгүүлэл/нэгдүгээр зохиогчоор 11, хамтарсан зохиогчоор 6/, дотоодын сэтгүүлд 34 өгүүлэл/нэгдүгээр зохиогчоор 25, хамтарсан зохиогчоор 9/ хэвлүүлсэн байна.

Багш нарын судалгааны хувьд боловсрол судлалын чиглэлээр 12 өгүүлэл /27 хувь/, хэл шинжлэлийн чиглэлээр 13 өгүүлэл /30 хувь/, орчуулгын чиглэлээр 2 өгүүлэл /5 хувь/ хэвлэгдсэн байна.

### **Төгсөгчдийн ажил эрхлэлт /2018-2021/**

Тус салбарын төгсөгч нар Монгол улсад япон хэл зааж буй их дээд, сургууль, ерөнхий боловсролын сургуулиуд, засгийн газар, төрийн байгууллагууд, шинжлэх ухааны байгууллага, хүрээлэнгүүд, Япон улсын ЭСЯ, ЖАЙКА болон олон улсын байгууллагууд, хувийн хэвшлийн салбар, Японы хөрөнгө оруулалт бүхий компани, байгууллагад эзэмшсэн мэргэжлээрээ ажиллахын зэрэгцээ өөрсдийн хувийн компани зэргийг байгуулан олон салбарт Монгол-Японы харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

2021 онд сүүлийн гурван жилийн төгсөгчөөс судалгаа авсан бөгөөд уг судалгаанд орчуулгын ангийн 19 төгсөгч буюу 68 хувь нь оролцсон. Үүнээс судалгаанд оролцсон төгсөгчийн 50 хувь гаруй нь үргэлжлүүлэн гадаад болон дотоодод суралцаж байгаа бөгөөд төгсөгчдийн 58 хувь нь Япон хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалтын дундаас дээш түвшин болох N3-N1 түвшинд тэнцэн сертификат авсан байна.

#### *“Гадаад хэлний орчуулга (Япон хэл)” хөтөлбөрөөр төгсөгчдийн ажил эрхлэлт*

Ажил эрхэлж буй төгсөгчдийн судалгаанаас үзэхэд, дийлэнх нь төгсөөд жилийн дотор ажилд ордог байна. Түүнчлэн ажлын байрандаа ихэвчлэн олон нийттэй харилцах, баримт бичиг, төлөвлөгөө, тайлан боловсруулах, орчуулга хийх зэрэг үүрэгтэй ажиллаж байгаа нь хөтөлбөрт тусгагдсан харилцаа болон бичгийн чадамжийн олон зорилт амжилттай хэрэгжсэний баталгаа юм. Төгсөгчдийн 85 хувь орчим нь мэргэжилтэйгээ тодорхой хэмжээнд холбогдолтой ажил эрхэлж байна.

### III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

#### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

##### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

#### Илрэл нотолгоо:

- МУИС-ийн хөтөлбөрийн хорооноос 2013 онд гадаад хэлний хөтөлбөрт хийсэн шинжилгээний үр дүнд үндэслэн, 2014 онд хөтөлбөр сайжруулах нийтлэг зөвлөмжийг тэнхимүүдэд хүргүүлэн, 2015 онд хөтөлбөрийн шинэчлэлт хийсэн.
- Тус хөтөлбөр нь 2013 онд Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр магадлан итгэмжлэгдсэн
- Тэнхмийн үйл ажиллагааны төлөвлөгөө 2020-2021

#### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

#### Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийг боловсруулахад баримталсан олон улсын болон үндэсний чиг хандлагыг тодруулах бенчмаркийн судалгаа болон хөтөлбөрийн чанарын баталгааг хангах үйл явцыг харуулсан PDCA судалгаа, STEEP шинжилгээг хийсэн.
- Стэнфордын их сургууль, Сингапурын их сургууль, Оосакагийн Их сургууль, Москвагийн хэл шинжлэлийн улсын их сургууль, Канда гадаад хэлний их сургууль зэрэг их сургуулиуд, болон дотоодын Хүмүүнлэгийн ухааны их сургууль, Соёл эрдэм дээд сургуулиудын сургалтын төлөвлөгөөг харьцуулан судалсан.

##### 1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

#### Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлохдоо боловсролын тухай хууль, дээд боловсролын тухай хуулийн холбогдох заалтуудад үндэслэн боловсруулсан байна.
- Хөтөлбөрийн зорилгыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан эрх зүйн болон бодлогын баримт бичиг болон МУИС-ийн алсын хараа, эрхэм зорилго стратеги зорилттой нийцүүлэн боловсруулсан.



- МУИС-ийн бакалаврын хөтөлбөрүүдийн эрхэм зорилго, олгох мэдлэг, ур чадвар, хандлага, ирээдүйн ажлын байр, томоохон ажил олгогч зэрэг мэдээллийг тусгасан товч танилцуулгатай мэргэжлийн хөтөлбөрийн танилцуулгыг хэвлэмлээр болон хөтөлбөрийн цахим хуудсаар оюутан, эцэг эх, багш, сонирхсон хүмүүст тогтмол түгээдэг, сургалтын төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийг баталгаажуулан МУИС-ийн вэбсайт, SiSi сургалтын удирдлагын системд цаг тухай бүрд оруулдаг байна.

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- “Гадаад хэлний орчууга (Япон)” хөтөлбөрийг МУИС-ийн алсын хараа, эрхэм зорилго, стратегийн тэргүүлэх чиглэлд суурилан, “Европын олон хэлний суурь хөтөлбөр”, “JF2010 Япон хэлний боловсролын стандарт” 12 зэрэгт тулгуурлаж боловсруулсан.
- ЕОХСХ-т суралцагчийн ерөнхий чадварыг декларатив, гүйцэтгэх ур чадвар, экзистенциал чадамж, сурах чадвар гэж 4 ангилсан байдаг бөгөөд үүнийг суралцагчийн мэдлэг, ур чадвар, хандлага, сурах чадвар гэсэн 4 чадамжтай дүйлгэн хөтөлбөрт тусгасан.
- “Гадаад хэл, орон судлал (Япон)” Гадаад хэлний орчуулга (Япон хэл)” хөтөлбөрүүдийн төгсөгчийн загварыг мэргэжлийн мэдлэг, мэргэжлийн ур чадвар, хувь хүний ур чадвар, сэтгэлгээ, хэлний мэдлэг чадвар гэсэн 5 чиглэлээр гаргаж боловсруулсан. Тус 2 хөтөлбөрийн мэргэжлийн мэдлэг 100 хувь ялгаатай, мэргэжлийн ур чадвар 1 чадвараар ялгаатай бол хувь хүний ур чадвар, сэтгэлгээ, хэлний мэдлэг чадвар гэсэн 3 чиглэл нь ижилхэн байна.
- Хөтөлбөрийн зорилго, төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлохдоо холбогдох салбар шинжлэх ухааны мэргэжилтэн, судлаачдын саналыг тусгаж ажилласан.
- Хөтөлбөрийн төгсөгчийн загвар боловсруулсан.

### Анхаарах асуудал:

- Төгсөгчид болон ажил олгогчдын саналыг хөтөлбөрт тусгах ажлыг тогтмолжуулах

### Зөвлөмж:

- Хөтөлбөрийн зорилгын өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлж, оролцогч талуудыг саналыг тусган сайжруулах үйл ажиллагааг тогтмолжуулах

### 1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

### Илрэл нотолгоо:

- Гадаад хэл, орон судлал (Япон) сургалтын хөтөлбөр
- Өөрийн үнэлгээний тайлан

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

## Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор хөтөлбөрийн ерөнхий хороо, салбар хороодууд тодорхой төлөвлөгөөтэй ажлууд зохион байгуулж, тайлагнадаг
- Төгсөгчийн хүрэх үр дүнг (PLOs) үйлээр илэрхийлэн тодорхойлсон
- Сургалтын төлөвлөгөөний хичээлүүд ба хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт хоорондын хамаарлыг харуулсан сургалтын төлөвлөгөөний матриц хийгдсэн

## Анхаарах асуудал:

- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгаа, түүнд дүн шинжилгээ хийх

## Зөвлөмж:

- Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүдэд оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулах

**1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

### 2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

## Илрэл нотолгоо:

- “Гадаад хэлний орчуулга (Япон хэл)” хөтөлбөрийн лекц, семинарын харьцаа, шинжилгээ Лекц 30%: Семинар 65%: Бие даан гүйцэтгэх ажил 5% байна. Хэлэхүйн чадвар эзэмшүүлэх багц хэсэг нь “JF2010 япон хэлний боловсролын стандарт”-д үндэслэсэн бөгөөд “Боловсрол судлал-ГХЗА” профессорын багийн “Гадаад хэлний мэргэжлийн суурь хичээлийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах нь” төслийн хүрээнд гадаад, дотоодын ижил төстэй хөтөлбөрийн агуулгад хийсэн баримтын судалгааны үр дүнд боловсруулж тогтоосон.
- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (33) болон хичээлийн суралцахуйн үр дүн (200)-гийн матриц
- Хөтөлбөрийн үр дүн буюу мэдлэг, чадвар, хандлагыг хэлний болон орчуулга, хэлмэрчлэхүй талаас нь томъёолсон ба мэдлэг 9, чадвар 11, хандлага 13, нийт PLO 33 байна.
- Оюутны дадлага хийсэн байдал, шинжилгээ
- Хамтын ажиллагаатай 10 гаруй байгууллагад 56 оюутан дадлага хийсэн ба үүнээс 3 нь Япон улсад дадлагажжээ. Гадаад хэлний орчуулга (Япон хэл)” хөтөлбөрийн оюутнууд 2017-2018 оны хичээлийн жилд 100 хувь их, дээд сургууль, ЕБС, гадаад хэлний сургалтын

төвд үйлдвэрлэлийн дадлага хийдэг байсан бол 2018 оноос дадлагын газрын тоо, төрөл нь ч нэмэгдсэн байна.

- Оюутны дадлага хамтран удирддаг байгууллагуудын нөхцөл байдлын судалгаа
- “Гадаад хэлний орчуулга (Япон хэл)” хөтөлбөрийн агуулгын залгамж холбоог харуулсан загвар
- Суралцагчдын хичээл болон багшийг сонгосон байдал
- Суралцагчдын сонгон судлах хичээлийг сонгосон байдал

### **Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага**

- Гадаад, дотоодын ижил төстэй хөтөлбөрийн агуулгад хийсэн баримтын судалгаанд үндэслэн, хэлний онолын мэдлэг, семинар дадлага, бие даан гүйцэтгэх ажлын эзлэх тоо, хувийг тогтоосон.
- Бэлтгэх, хэрэгжүүлэх, тайлагнах үнэлэх гэсэн 3 үе шаттай дадлагыг намрын улиралд 6 долоо хоног, 3 багц цагаар гүйцэтгэдэг ба сүүлийн 4 хичээлийн жилийн байдлаар харьцуулан, дүн шинжилгээ хийжээ.
- Мэргэжлийн сонгон судлах хичээлийг сонгосон байдалд дүгнэлт хийж, судалсан оюутны тоо харьцангуй цөөн байгаад нөлөөлж буй хүчин зүйл болон түүний шийдэл, арга замыг тодорхойлсон.
- Шинжлэх ухааны үндсэн салбаруудыг хамарсан чөлөөт мэдлэг буюу “либерал арт” уламжлалд суурилсан сургалтын хөтөлбөртэй. Ерөнхий суурь хичээл (А) 36 багц цаг, Мэргэжлийн суурь хичээл (Б) 9 багц цаг, Мэргэжлийн хичээл (В) 60 багц цаг, Чөлөөт сонголтын хичээл (Г) 15 багц цаг, ГХМҮ 1 багц цаг, нийт 121 багц цаг бүхий, тайлбар болон төгсөгчдөд тавих хөтөлбөрийн шаардлагыг тусгасан байна. Чөлөөт сонголтын хичээл (Г) нь мэргэжлийн сонгон судлах хичээлийг үндсэн мэргэжлийн тодорхой салбараар нарийсган, сонгон суралцах боломжид нийцүүлэх зорилготой, 15 багц цагийн багтаамжтай.

#### **Анхаарах асуудал:**

- Ерөнхий суурь хичээл (А), Мэргэжлийн суурь хичээл (Б), Мэргэжлийн хичээл (В) тус бүрийг заавал болон сонгон судлах хичээл гэсэн 2 хэсэгтэйгээр төлөвлөөгүй.
- Ерөнхий суурь хичээл (А) хэсэгт хичээлийн нэрийг тодорхой бичээгүй.
- Мэргэжлийн суурь хичээл (Б) хэсэг нь Б2 буюу зөвхөн сонгон судлах хичээл гэсэн хэсэгтэй. Тэдгээр сонгон судлах хичээлийн жагсаалт дотор буй Орчуулгын онол 3 багц цагийн хичээлийг заавал судлах тухай тайлбар оруулсан нь цагийн харьцааны хувьд зохистой бус байна.
- Мэргэжлийн суурь хичээл (Б), Мэргэжлийн хичээл (В) хэсгийн бүх хичээл буюу 39 хичээлийн цагийн багтаамж 3 багц цаг байгаа нь оновчгүй.
- Хөтөлбөрийн үр дүн (PLO) хэт олон, оновчтой томъёолоогүй.
- Төгсөгчдийн эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг оролцогч талуудын саналыг тусгаж тодорхойлоогүй.
- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (PLO) болон мэргэжлийн хичээлийн суралцахуйн үр дүн (CLO)-гийн хамаарлыг харахад тоо харилцан адилгүй буюу хэт олон, хэт цөөн байна. Тархалт жигд бус байна.

- Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан загварт уялдаа холбоо, залгамж чанарыг сайн зураглаж гаргаагүй.

### **Шаардлага:**

- Сургалтын хөтөлбөрийн бүтэц, харьцааг БСШУЯ-ны сайдын 2014 оны А/174 тоот тушаалд нийцүүлж, “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ыг хэрэгжүүлэх
- Ерөнхий суурь хичээл (А), Мэргэжлийн суурь хичээл (Б), Мэргэжлийн хичээл (В)-ийг тус бүрт нь заавал болон сонгон судлах хичээл гэсэн 2 хэсэгтэйгээр төлөвлөх
- Ерөнхий суурь хичээл (А) хэсэгт судлагдахууны чиглэлийг бус, хичээлийн нэрийг тодорхой тусгах
- Гамшгаас хамгаалах менежментийн үндэс хичээлийг Ерөнхий суурь хичээл (А)-ийн заавал судлах хичээлд багтаах
- Мэргэжлийн суурь хичээл (Б), Мэргэжлийн хичээл (В) хэсгийн бүх хичээл 3 багц цаг байгааг өөрчилж, хичээлийн агуулга, арга зүй, үнэлгээ, жин, багтаамжид нийцүүлэн, ялгамжтай болгох
- Хөтөлбөрийн үр дүн болон хичээлийн үр дүнгийн хамаарлыг PLO-CLO-хичээл гэсэн байдлаар матриц гаргаж, шинжилгээ хийх
- Хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын саналд үндэслэж, мэргэжлийн хичээлүүдэд өөрчлөлт оруулах
- А/103, А/285 болон А/262 тоот тушаалыг хэрэгжүүлэх

### **2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Мэргэжлийн хичээлд хэрэглэдэг идэвхтэй болон идэвхгүй сургалтын аргын харьцаа
- Сургалтын арга зүйн матриц
- Идэвхтэй сургалтын аргыг хэрэглэж буй байдал, харьцуулалт
- Идэвхгүй сургалтын аргыг хэрэглэж буй байдал, харьцуулалт
- Сургалтын арга зүйн талаарх оюутны сэтгэл ханамжийн судалгаа
- Оюутнуудаас авсан цахим сургалтын талаарх судалгаа

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Мэргэжлийн хичээлд хэрэглэж буй сургалтын арга зүйн судалгаа хийсэн.
- Багаар ажиллах, илтгэл хэлэлцүүлэх, санаа бодлоо солилцох, тоймлон ярих, харилцан ярих, судалгаа хийх, дүн шинжилгээ хийх зэрэг нь бүх хичээлд давтамжтай буюу 100 хувь хэрэглэдэг.
- Цаг үеийн нөхцөл байдалтай уялдан, оюутнуудаас цахим сургалтын талаар 2020-2021 оны хичээлийн жилийн намар, хаврын улиралд сэтгэл ханамжийн судалгааг сургуулийн

хэмжээнд авч, үр дүнг нэгтгэсэн. Уг судалгаанаас харахад цахим сургалтын үед тулгарсан хүндрэл, бэрхшээл, асуудлаа бүлэглэж авч үзжээ.

#### **Анхаарах асуудал:**

- Арга зүйн судалгаанд тусгагдсан сургалтын зарим арга зүйг хичээлийн хөтөлбөрүүдээс харах боломжгүй байсан.
- Цахим сургалтын талаар авсан оюутнуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг суралцаж буй хөтөлбөрөөр нь ялгаагүй.

#### **Зөвлөмж:**

- Сургалтын арга зүйн үр дүнд тогтмол судалгаа хийж сайжруулдаг байх
- Хичээлд хэрэглэж буй арга зүй нь оюутнаар мэдлэг бүтээлгэх, бие даасан суралцахуйг дэмжихэд чиглэх

### **2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУИС-ийн сургалтын журам дахь үнэлгээний аргачлал, харьцаа, шалгуур
- “Гадаад хэлний орчуулга (Япон хэл)” хөтөлбөрийн шалгалтын хэлбэр, хувилбар, дасгалын тоо, хугацаа, даалгаврын төрөл, хэлбэр, дүн шинжилгээ ба чанарын үнэлгээг тусгасан.
- Мэргэжлийн хичээлийн үнэлгээний төрлийг тоймлосон. 26 хичээл буюу 92 хувьд нь хичээлийн явцад албан бус үнэлгээ хэрэглэдэг бол 7 хичээл буюу 25 хувьд нь оюутныг давлах хүснэгтийн тусламжтайгаар үнэлэх аргыг хэрэглэж байна.
- Түвшин (2-4) бүрийн оюутнуудын сурлагын амжилт, үсгэн үнэлгээний харьцаа, түүний шинжилгээ

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багш нар улирлын эхэнд хичээлийн үнэлгээний арга, задаргааг суралцагчдад тодорхой танилцуулдаг. Багш нар оюутны хандлагын түвшин буюу хичээлийн ирц, оролцоо, хичээлд бэлтгэсэн болон оролцсон байдал зэргийг үнэлгээнд чухалчилдаг.
- 2015-2020 оны хичээлийн жилд суралцсан 2-4 дүгээр түвшний оюутнуудын дүн, сурлагын амжилтад дүн шинжилгээ хийсэн байна.

#### **Анхаарах асуудал:**

- Блумын таксономи, үнэлгээний рубрикийг хичээлийн хөтөлбөрөөс харах боломжгүй.
- Оюутнууд өөрийн үнэлгээнд суралцах арга зүй хөтөлбөрт тусгагдаагүй

#### **Зөвлөмж:**

- Үнэлгээний зорилго, шалгуур, шалгуурын түвшин бүрийн оноо, хийх аргачлалыг тусгасан үнэлгээний рубрикийг хувилбартайгаар боловсруулах
- Хичээл нэг бүрийн үнэлгээний арга, хэлбэр нь суралцагчдыг хөгжүүлэхэд чиглэх
- Суралцагчийн сурлагын ахиц, амжилтад хийсэн анализ, статистик мэдээллийг үнэлгээний арга зүйг сайжруулахад ашиглах

## 2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

### Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

#### 3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

#### Илрэл нотолгоо:

- Сургалт судалгааны орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх стандартын шаардлага хангасан байна. Үүнд:
  - Сургалтын болон шинжлэх ухааны лабораториуд бүхий корпус;
  - Хичээлийн анги танхим судалгаа, эрдэм шинжилгээний лаборатори, захиргаа;
  - Номын сан, лаборатори;
  - Багш ажилчдын ба оюутны байр, хүн эмнэлэг;
  - Спорт комплекс /баригдаж байгаа/ бүхий барилга байгууламжтай.
- Хичээлийн II байр нь 12,551 м<sup>2</sup> талбай бүхий 4 давхар барилга байгууламж бөгөөд хичээлийн байр нь 6,508 м<sup>2</sup> талбайтай, 190 өрөөний 112 нь хичээлийн, 47 нь тэнхим, багш, мэргэжилтнүүдийн өрөө юм.
- Оюутны I, II байртай, нэг өрөө нь 16 м<sup>2</sup>, 4 оюутан байрлахаар тохижуулсан, нэг оюутанд 4 м<sup>2</sup> талбай ногдож байгаа нь нормативыг хангаж байна.
- Багш нарын ажилладаг тэнхимийн өрөөний хүртээмж нэг багшид ноогдох ашигтай талбай 40.3 м<sup>2</sup> байгаа нь стандартын шаардлага хангаж байна. Бүх багш нар танхимын болон цахим хичээл хийх дагалдах хэрэгсэл болох чихэвч, микрофон, камераар 100% хангагдсан.
- Тус хөтөлбөрийн мэргэжлийн болон сонгон судлах нийт 40 хичээлд түгээмэл хэрэглэгддэг техник хэрэгслийн 12 өгөгдөл бүхий судалгааны дүнгээс үзэхэд, мэргэжлийн, сонгон судлах нэгж хичээлд дунджаар 6.1 хэрэгсэл оногдож байгаа нь хөтөлбөр хэрэгжүүлдэг япон судлалын салбар техник, тоног төхөөрөмжөөр сайн тоноглогдсон болохыг илтгэж байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### Онцлог зүйл/Туршлага:

- Оюутнууд хичээлийн байрны аль ч талбай хонгилд хичээл хийх ширээ сандал, цахилгааны эх үүсвэр, утасгүй интернэт бүхий цахим орчноор хангагдсан байдаг тул, оюутан бие даан сурах, даалгавар хийх, багаар ажиллах орчинг бүрдүүлсэн байна.
- “Гадаад хэлний орчуулга (Япон хэл)” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай анги, танхим тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, лабораториуд болон бусад хэрэгцээт орчныг сүүлийн таван жилд сургуулийн төлөвлөгөөт санхүүжилтээр шинэчилж, суралцах таатай орчныг улам боловсронгуй болгон бүрдүүлсэн
- Ажлын байрны орчин, нөхцөлийн талаар багш, ажилтнаас сэтгэл ханамжийн тогтмол судалгаа авдаггүй боловч тэнхимийн болон салбарын хурлаар ажиллах орчныг сайжруулах, техник хэрэгслийг сайжруулах, нэмэгдүүлэх талаар санал асууж, хамт олны саналаар нэн шаардлагатай хэрэгжүүлэх дарааллыг тогтоон, салбар сургуульд тавьж шийдвэрлүүлдэг зэрэг нь сургалтын орчинг сайжруулах шинэчлэл тогтмол хийгддэг байна.
- МУИС-ийн харьяа эмнэлэг нь Нийслэлийн Эрүүл Мэндийн Төвийн тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулдаг. Тус эмнэлэг нь эмчийн үзлэг, оношилгоо, физик эмчилгээг МУИС-ийн нийт оюутан, суралцагсад, багш ажилтнуудад тасралтгүй хүргэснээр оюутан, сурагчдын эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрохоос гадна эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээг нийт оюутнуудад хүргэн ажилладаг.

#### **Анхаарах асуудал:**

- Хичээлийн байрны дулаан, гэрэлтүүлэгт анхаарах

### **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- “Гадаад хэлний орчуулга (Япон хэл)” хөтөлбөрийн багш нар МУИС-аас тодорхой хугацаатай ба урт хугацаатайгаар лицензийг нь худалдан авч ашиглах боломжтой программыг ашиглахаас гадна багш нар олон улсын хурал зохион байгуулах, гаднын байгууллагуудтай хамтарсан хурал, сургалт, хэлэлцүүлэг хийх зорилгоор зарим лицензтэй программыг багш, ажилтан дэмжих зардал, эрдэм шинжилгээний зардлаас авч хэрэглэдэг.
- Хөтөлбөрийн мэргэжлийн болон сонгон судлах хичээлд түгээмэл хэрэглэгддэг программ хангамжийн 11 өгөгдөл бүхий судалгааны дүнгээс үзэхэд, мэргэжлийн болон сонгон судлах нэгж хичээлд 3,4 программ хангамж хэрэглэгддэг байна.
- Хөтөлбөрийн багш нар сургуулийн албан ёсны SiSi сургалтын мэдээллийн системээр ирц бүртгэх, сургалтын хэрэглэгдэхүүн, дасгал даалгавар, үнэлгээ, мэдээ мэдээлэл суралцагчдад хүргэхээс гадна facebook, instagramm, clubhouse, цахим шуудан, zoom, youtube зэрэг олон платформыг суралцагчдын боломж бололцоонд тулгуурлан сургалтад туршин, ашиглаж ирснээс гадна цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан Микрософт тиймс (Microsoft Teams) платформыг албан ёсоор сургалтдаа 100% нэвтрүүлсэн байна.

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- Сургалт, судалгааны программ хангамж, тоног төхөөрөмж сайн, шинэчлэн сайжруулах ажил тогтмол хийдэг.
- Тус хөтөлбөрийн онцлогт тохирсон Digital Language Laboratory (DLL), Software build in XCLASS System, XCLASS Digital Multimedia, Teaching Software, Student License, XCLASS Digital Multimedia, Teaching Software, Teacher License зэрэг программуудыг сургалтад хэрэглэж хэвшсэн, сургалтад ашиглахад шаардлагатай хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцийг бүрдүүлсэн байна.

### Анхаарах асуудал:

- Цахим хичээл боловсруулах ажлыг эрчимжүүлж, сургалтад нэвтрүүлэхэд анхаарах

### 3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

### Илрэл нотолгоо:

- Олон улсын номын сангийн автоматжуулсан КОНА цогц программ хангамж өгөгдлийн бааз ашиглах, дэлхий нэр хүндтэй их сургуулиудын онлайн сэтгүүл, е-номын сан ашиглах боломж бүрдүүлсэн зэрэг дэвшилтэт технологиудыг нэвтрүүлсэн байна.
- Номын сан нь 2020-2021 оны хичээлийн жилд 390,000 гаруй хэвлэмэл болон цахим бүтээлийн сан хөмрөгтэй, олон улсын онлайн мэдээллийн сангуудыг ашиглах боломжийг бүрдүүлэн үйлчилдэг.
- 875 оюутанд үйлчлэх номын сан нь нийт 390 000, үүний 54 хувь нь монгол, 36 хувь нь орос, 10 хувь нь англи болон бусад хэл дээр хэвлэгдсэн ном, бүтээлүүд, тэр дундаа тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ашигладаг Япон судлалын 798 төрлийн ном, 31 төрлийн сурах бичиг, 59 төрлийн толь бичиг, 115 тооны MA ажил, 13 тооны PhD диссертаци, 14 төрлийн ЭШ-ний сэтгүүл байна.
- Үүнээс гадна тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр хангадаг Монгол-Японы төв нийтэд нээлттэй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд сургуулийн болон олон улсын төсөл, хөтөлбөрийн шугамаар тогтмол шинэчлэл хийгддэг.

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- Цахим сан хөмрөгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд цаасан магистрын ажлыг 100% МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг, номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж буй докторын судалгааны бүтээлийн 80% -ийг цахим хэлбэрт хөрвүүлэн ашиглаж байна.
- Тус хөтөлбөрийг хариуцан хэрэгжүүлэгч нэгж болох Ази судлалын тэнхимийн харьяанд хятад, солонгос, япон, турк судлалын 4 номын фондтой. Давхардсан тоогоор хөтөлбөрийн нийт 58 хичээлд хэрэглэх ном, сурах бичиг, толь бичиг зэрэг хэрэглэгдэхүүнээр тасралтгүй хангах зорилгоор өөрсдийн нөөц бололцоондоо тулгуурлан фондоо тодорхой хэмжээнд



шинэчилж, сайжруулсаар ирсэн бөгөөд 4400 ширхэг ном, сурах бичиг болон бусад хэрэглэгдэхүүн бүхий номын сан тэнхимийн дэргэд ажилладаг.

**Зөвлөмж:**

- Тухайлсан салбаруудын нэр томъёоны толь бичиг гаргахад чиглэсэн үйл ажиллагааг төгсөгчидтэй хамтран боловсруулах ажлыг эхлүүлэх

**3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

**Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

**4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Сургуулийн хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын алба 2017 онд байгуулагдаж, 2018 оноос Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс /ХЧБХ/ ажиллах журмыг шинэчлэн баталсан.
- Эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтэд шинжилгээ хийж сайжруулан шинэчлэн баталж ирсэн.
- Элсэх, шилжих, төгсөх, мэргэжлийн хөтөлбөр сонгох, дүгнэх гэх мэт сургалтын үйл ажиллагаанууд SiSi системээр явагддаг учраас ихэнх журмын хэрэгжилтийг хянах боломж бүрдсэн.
- Сургалтын удирдлага мэдээллийн SiSi системтэй

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн дунд, богино хугацааны төлөвлөгөө боловсруулж биелэлтийг тайлагнадаг.

**Анхаарах асуудал:**

- Хөтөлбөртэй холбоотой ирсэн санал гомдлыг шийдвэрлэхэд анхаарах

**Зөвлөмж:**

- Хөтөлбөртэй холбоотой ирсэн санал гомдлыг бүртгэлжүүлж, шийдвэрлэсэн байдлын тайланд шинжилгээ хийж үр дүнг хөтөлбөрийн сайжруулалтад тусгах

#### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд гадаад дотоодын 50 байгууллагатай хамтран ажиллаж байна. Үүнд Гадаадын 16, дотоодын 34 байгууллага, төрийн хэвшлийн 8, хувийн хэвшлийн 12 (сургалтын төв, сангууд, банк, холбоод багтана), их дээд сургууль болон судалгааны хүрээлэн нийгэмлэг 24, дунд сургууль 5 байна.
- Суралцагчид 14 төрлийн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагддаг, тайлант жилийн хугацаанд нийт гадаад дотоодын 10 сангаас 23 оюутан тэтгэлэг авчээ. Үүнээс гадаадын 4 сангаас тэтгэлэг авч, японд суралцсан оюутан 17, дотоодын 6 сангаас тэтгэлэг авсан оюутан 6 байна.
- “МУИС Япон судлал 2-4 курс” нэртэй веб групп нээн ажиллуулдаг.
- Нийгэмд үзүүлж буй хамтын ажиллагаа, үйлчилгээний агуулгаас харахад, сургалт, шалгалт шүүлэг, судалгааны үйлчилгээ голлож байгаа бөгөөд Японы соёлыг таниулах тал дээр түлхүү ажиллаж, 10000 гаран хүнд үйлчилсэн байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг 3 хэлбэрээр явуулдаг.
  - Нийгэм олон нийтэд чиглэсэн олон нийтийг хамарсан шалгалт шүүлэг авах, уралдаан тэмцээн явуулах, өдөрлөг тэмдэглэлт үйл явдал зохион байгуулах, эрдэм шинжилгээний хурал, сургалт симпозиум зохион байгуулах, мэргэжлийн холбогдолтой заавар зөвлөгөө мэдээ мэдээлэл өгөх, олон нийтийн ашгийн бус байгууллагатай хамтран ажиллах зэрэг үйл ажиллагаанууд хийгддэг.
  - Өөрийн сургуулийн оюутан багш нарт чиглэсэн анги удирдаж оюутнуудад зөвлөгөө өгөх, хээрийн хичээл явуулах, спорт, урлагийн тэмцээн явуулах, дадлага хийлгүүлэх, оюутны эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, хичээлийн хөтөлбөр сурталчлах, мэргэжлийн зэрэг хамгаалуулах, мэргэжлийн зөвлөгөө өгөх, дугуйлан удирдах, оюутныг гадаад дотоодын тэтгэлэгт хөтөлбөрт тодорхойлон явуулах, бусад ижил төстэй байгууллагад заавар зөвлөмж өгөх үйл ажиллагаанууд хийгддэг
  - Мэргэжлийн дагуух үйл ажиллагаа, тодруулбал эрдэм шинжилгээний хурал, симпозиум, сургалт зэрэг холимог үйл ажиллагаа гэсэн гурван чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.
- Тэтгэлэг авсан оюутныг хөтөлбөрөөр нь харвал Япон хэл – орон судлал хөтөлбөрийн оюутан 13 байна.
  - Дотоодын бусад тэтгэлэг: 9000000 төгрөг
  - Японд суралцаж бэлэн болон бэлэн бус байдлаар авсан тэтгэлэгийн мөнгөн дүн 33562000 иен буюу 883351840 төгрөг

- Доктор багш нар өөрийн судалгааны ажилд оюутнуудыг оролцуулж, суурь судалгааны зардлаасаа оюутнуудад тэтгэлэг олгодог-3 оюутанд 500000 төгрөгийн тэтгэлэг олгосон.

#### **Анхаарах асуудал:**

- Солилцооны болон тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах багш суралцагчдын тоог нэмэгдүүлэхэд анхаарах
- Төгсөгчдийн холбоог албан ёсоор байгуулахад нөөц боломжоо ашиглах
- Төгсөгчдөөс давтан сургалтад хамрагдах хэрэгцээний судалгааг тогтмолжуулах

#### **Зөвлөмж:**

- Солилцооны болон тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах багш суралцагчдын тоог нэмэгдүүлэх, ялангуяа дотоодын тэтгэлэгийг татах чиглэлээр мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага МУИС-ын төгсөгчдийн холбоотой гэрээний дагуу хамтран ажиллах
- “МУИС Япон судлал 2-4 курс” нэртэй веб группыг өргөжүүлэн төгсөгчдийн холбоог албан ёсоор байгуулж, хөтөлбөрийн элсэлт болон суралцагчдын дадлага хийх үйл ажиллагаанд татан оролцуулах боломжийг эрэлхийлэх
- Төгсөгчдөөс давтан сургалтад хамрагдах хэрэгцээний судалгаа авч судалгааны үр дүнг хөтөлбөрийн сайжруулалтад ашиглах

#### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУИС-ийн Санхүүгийн албанаас гаргаж өгсөн 2019, 2020 оны санхүүгийн тайлангийн задаргаанаас харахад, 2019 оны санхүүгийн жилд 3,64 хувийг, 2020 оны санхүүгийн жилд 3,82 хувийг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагаанд зарцуулжээ.
  - 1 багц цагийн төлбөр 1-р курст 98,600 төгрөг, 2-4-р курс 100,700 төгрөг
  - Хөтөлбөрийн 1 оюутны жилийн сургалтын төлбөр нь 2,524,956.10
  - Профессор, дэд профессорын суурь судалгааны зардал - 523350 төгрөгөөр, багш дэмжих зардал 213221, Хичээл практикийн зардал 138024, Тоног төхөөрөмжийн зардал 2648880 төгрөгөөр нэмэгдсэн бусад зардал -8406567 төгрөгөөр буурсан байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Зориулалтын задаргаанаас харахад 2019 -2020 онд нэгжийн орлогоос
  - цалинд 59,82%-60,3% болж өссөн.
  - судалгааны зардалд 3,68%-0,98% болж буурсан.
  - нийгмийн халамжийн зардалд 0,65%-0,71% болж өссөн.
  - сургалтын орчныг сайжруулах зардалд 6,85%-9,74% болж өссөн.

- бусад зардал буюу оюутны үйл ажиллагаанд зориулсан зардалд 12,12%- 6,76% буурсан.
- нэгж 2019-2020 онд МУИС-д 82,806,872 төгрөг буюу 16,85%-21,45 %(108,253,920) орлого болж өссөн.
- Хувийн хэвшлийн зүгээс тус хөтөлбөрийг дэмжин ажиллах анхны үйл ажиллагаа “Монгол улсад япон хэлтэй боловсон хүчин бэлтгэж эхэлсний 40 жилийн ойн арга хэмжээ”-тэй холбогдуулан эхэлсэн. Тус үйл ажиллагаагаар байгууллага, хувийн хэвшил, хувь хүн нийлээд 52 газраас 48.622.599 төгрөгийн дэмжлэг туслалцаа үзүүлсэн байна.

#### **Анхаарах асуудал:**

- Хувьсах зардлын төсөвлөлт, зарцуулалтыг тооцдог байх

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөртэй холбоотой ирсэн санал гомдлыг бүртгэлжүүлж, шийдвэрлэсэн байдлын тайланд шинжилгээ хийж үр дүнг хөтөлбөрийн сайжруулалтад тусгах
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалтын үр ашгийг тооцдог байх
- Оюутныг хөгжүүлэх ур чадварын уралдаан, тэмцээн, дадлагын болон багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх чиглэлийн үйл ажиллагааны төсвийн зарцуулалтын үр дүнг тооцдог байх

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Мэргэжлийн хөтөлбөр сонгох үйл ажиллагааны өмнө оюутнуудад хөтөлбөрөө сурталчлах, таниулах өдөрлөгийг бүрэлдэхүүн сургууль, мэргэжлийн тэнхимүүд, холбогдох алба нэгжийн зүгээс зохион байгуулдаг.
- Гадаад, дотоодын их дээд сургууль төгсөж салбартаа амжилт гаргаж яваа мэргэжилтнүүд өөрсдийн туршлагаа оюутан залуустай хуваалцаж “Мэргэжлээ хэрхэн сонгох вэ”, “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ”, “Ирээдүйн чиг хандлагыг ойлгох” гэх мэт цуврал уулзалт ярилцлагыг зохион байгуулж зөвлөгөө өгдөг.
- Хөтөлбөр сурталчлах өдөрлөг нь тухайн хичээлийн жилийн намар болон хаврын улиралд тус бүр нэг удаа зохион байгуулагддаг.
- Хөтөлбөрүүдийн мэдээллийг Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчид, эцэг эхчүүдэд хүргэдэг.
- Хөтөлбөр, элсэлтийн мэдээллийг хэвлэмэл материал, видео танилцуулга байдлаар Сургалтын нэгдсэн албанаас бэлтгэж МУИС-ийн болоод бусад бүрэлдэхүүн, салбар сургуулиудын цахим хуудас [www.num.edu.mn](http://www.num.edu.mn), facebook, телевиз, FM, сонин, сэтгүүл болоод бусад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, БСШУСЯ, Аймаг орон нутгийн удирдлагууд, ТББ зэргээр дамжуулан хүргэдэг.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

## Онцлог зүйл/Туршлага:

- Тэнхимийн зүгээс комисс томилон, зохион байгуулалттайгаар салбар салбарын (Солонгос, Хятад, Япон, Турк, Араб) хөтөлбөрийн танилцуулга, тараах материал зэргийг хэвлэмэл байдлаар бэлдэн мэргэжил сурталчлах ажлыг багш оюутнуудын хамтаар идэвхтэй явуулдаг. 2015-2020 оны хооронд нийт 32 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулсан байна.
- “Монгол дахь Япон хэлний боловсрол ба Япон судлал 40 жил” сэдэвт баярын хурлыг зохион байгуулж, ном болгон хэвлүүлж нийтийн хүртээл болгов.
- “Жугамо” нийгэмлэгээс зохион байгуулсан явган аялалд оролцсон.
- МУИС-ийн Өвөр Зайсан дахь сургалт, судалгааны төвд Сакүра төгөл байгуулсан.
- Хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд нийт 15 ажил олгогч оролцсон ба үйл ажиллагааны чиглэлээр нь харвал сургалт эрхэлдэг 4, аялал жуулчлал эрхэлдэг 3, гадаад худалдааны чиглэлээр 2, японд ажиллах хүч гаргадаг 2, зөвлөх үйлчилгээ 1, гадаад дотоодын төрийн үйлчилгээний байгууллага 2, компьютер графикайн 1 компани байна. Эдгээр байгууллагад хөдөлмөр эрхэлдэг ажиллагсадын тоо 640, үүнээс хөтөлбөрөөр төгсөгчидөөс ажил эрхэлж байгаа хүний тоо 49 байгаа нь 7,65%-ийг эзэлж байна.

## Анхаарах асуудал:

- Хөтөлбөр сурталчлах үйл ажиллагаагы цар хүрээг өргөжүүлэхэд анхаарах
- Хөтөлбөрөөр төгсөгчдийг олон чиглэлээр ажиллах боломжийг бүрдүүлэхэд анхаарах

## Зөвлөмж:

- Хөтөлбөр сурталчлах үйл ажиллагааг МУИС-ийн 1-р түвшний оюутны хүрээнээс өргөжүүлж, нийт ЕБС төгсөгчид болон иргэд рүү чиглүүлэх
- Хөтөлбөрөөр төгсөгчдийг олон чиглэлээр ажиллах боломжийг бүрдүүлж, нарийн мэргэшүүлэх, давтан сургах

### 4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

## Илрэл нотолгоо:

- МУИС-д хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн танилцуулга, суралцахуйн зорилтод үр дүн, элсэгчид тавих шаардлага, сургалтын төлөвлөгөөний бүтэц, суралцах ачаалал, багц цаг, суралцахуйн үнэлгээний аргачлал зэрэг хөтөлбөртэй холбоотой мэдээллийг олон нийтэд нээлттэйгээр дараах албан ёсны эх сурвалжуудаар түгээдэг.
- МУИС-ийн сургалтын удирдлага, мэдээллийн SiSi системээр дэлгэрэнгүй мэдээллийг хүргэж, тогтмол шинэчилж байна.
- Цар тахалтай холбогдуулан хичээл заах, заалгуулах үйл ажиллагаа сүүлийн хоёр хичээлийн жилд цахим хэлбэрт шилжсэнтэй холбоотой Тиймс платформыг сургалтад идэвхтэй ашигладаг.

- Номын орчуулга, номын хандив ( Монгол улсын төв номын сан, Хүүхдийн номын сан, Улаанбаатар хотын номын сан болон түүний салбарууд, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв, МУИС-ийн номын сан, Эмэгтэйчүүдийн холбоо, МУИС-ийн Ази судлалын тэнхим зэрэг арваад байгууллага- 200 гаруй ном) зохион байгуулсан.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- “Гадаад хэлний орчуулга (Япон)” хөтөлбөрийн хариуцсан багш нар Мэдээллийн технологийн газартай хамтран ажиллаж, өөрийн хөтөлбөрийн онцлог давуу тал, оюутны тэтгэлэг болон төгсөгчдийн олж авах мэдлэг, чадвар, дадал, ажлын байрны талаарх мэдээлэл, видео бичлэгийг байршуулсан.
- Хөтөлбөрийн талаарх мэдээллийн хэрэглээ хангах байдлын судалгаа авдаг.
- Оюутнуудын 48,2 хувь нь хангалттай, 27,6 хувь нь зарим талаар хангалттай, сэтгэл ханамжтай гэж үнэлсэн байна.

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс гаргах сонин, сэтгүүл, ном товхимол гарын авлагад багш нарын оролцоог нэмэгдүүлэх

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс олон нийтэд чиглэсэн сонин, сэтгүүл, ном товхимол гарын авлагын тоо, цахим мэдээллийг сайжруулан тогтмол хүргэх

### **4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## **Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

### **5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт оюутан элсүүлэх журмыг жил бүр шинэчлэн боловсруулдаг ба журамд элсэлтийн бодлогын оруулдаг.
- “Бакалаврын өдрийн хөтөлбөрт шинээр элссэн суралцагчдад зориулсан чиглүүлэх сургалт”-ыг тухайн жилийн 8 сарын сүүлийн долоо хоногт зохион байгуулахаар тусгадаг. Чиглүүлэх сургалтаар МУИС-ийн сургалт, ёс зүй, оюутны үйлчилгээ, сургалтын

мэдээллийн системийн ашиглалттай холбоотой дүрэм журам, мэдээллийг дэлгэрэнгүй танилцуулдаг.

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- Элссэн оюутан үндсэн мэргэжлээс гадна МУИС-аас санал болгох хос болон хавсарга мэргэжлээс сонгон судлах боломжтой.

### 5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

### Илрэл нотолгоо:

- Элсэлт бүртгэлийн хэлтэс, Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс, Оюутан төгсөгчийн хэлтэс тухайн хөтөлбөрийн багш нартай хамтран шинээр элсэн суралцагчдад зориулж чиглүүлэх, танилцуулах үйл ажиллагааг жил бүр зохион байгуулдаг. Хичээлийн жилд 2 удаа хөтөлбөр сурталчлах өдөрлөг зохион байгуулж, 1-р түвшний оюутнуудад МУИС-ийн хөтөлбөрүүдийг танилцуулж, мэргэжлийн хөтөлбөрөө хэрхэн сонгох талаар мэдээлэл өгч, гарын авлага хэвлэн тараадаг.
- Хөтөлбөрийг хариуцсан багш нар уг арга хэмжээнд тогтмол оролцож, мэргэжил сонгож буй 1-р түвшний оюутнуудад зориулан хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхимийн танилцуулга, хөтөлбөрийн онцлог, ажлын байрны шаардлага, гадаад, дотоодын тэтгэлэгт хамрагдах боломж зэргийг тусгасан танилцуулах материал бэлтгэн тараах, уг хөтөлбөрөөр суралцаж төгссөн төгсөгчдийн видео танилцуулга хийж цахим орчинд түгээх, төгсөгч урьж оюутан-суралцагчийн ярилцлага хийх зэргээр ажиллаж байна. Тус хөтөлбөрийн багш, оюутнуудын зүгээс 2015-2020 онд жил бүр 2 удаа нийт 10 удаа хөтөлбөр сурталчлах үйл ажиллагаанд оролцжээ.
- Хөтөлбөрийн багш нар 2-4 дүгээр түвшинд суралцаж буй оюутнуудын хөтөлбөрийн зөвлөх багшаар ажиллаж, сургалтын журам, сургалтын үйл ажиллагаа, хөтөлбөртэй холбоотой зөвлөгөө өгч, зохих мэдээллээр ханган ажилладаг. Багш бүр хуваарийн дагуу бие даалттай өдөр оюутанд зөвлөгөө, давтлага өгөх цаг гаргаж, оюутнуудад хичээл, сургалттай холбоотой нэмэлт зөвлөгөө, давтлага авах боломжийг бүрдүүлсэн байна.
- Хөтөлбөрийн нийт оюутнуудад: МУИС-ийн оюутны цахим карт, нийтийн тээврээр хөнгөлөлттэй зорчих карт, ТҮЦ машинаас оюутны тодорхойлолт болон дүнгийн лавлагаа, сургуулийн цахим үйлчилгээнд бүртгүүлэх, утасгүй сүлжээнд нэвтрэх эрх нээлгэх, оюутны байранд орох хүсэлт, хичээл сонголт болон сургалтын төлбөр төлөх, шилжих болон төгсөх хүсэлт гаргах зэрэг үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломжийг бүрдүүлсэн байна.

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн оюутнууд МУИС-ийн эмнэлгээс нийт оюутнуудад зориулж зохион байгуулдаг вакцинжуулалт, сүрьеэгийн үзлэг, рентген зураг авах, оюутны байранд орох эрүүл

мэндийн үзлэг, эрүүл мэндийн сургалт зэрэг арга хэмжээнд оролцдог бөгөөд МУИС-ийн эмчийн үзлэгийн бүртгэлээс үзэхэд 2016-2017 оны хичээлийн жилээс хойш өнөөг хүртэл давхардсан тоогоор 71 оюутныг МУИС-ийн эмчийн үзлэгт хамруулсан зэрэг эрүүл мэндийн зөвлөн туслах үйлчилгээг үзүүлжээ.

- Гадаад, дотоодын тэтгэлэгт хөтөлбөрүүд болон гадаадын их сургуулиудад оюутнуудыг тодорхойлох захиа илгээх, сонгон шалгаруулалтын бичиг баримт бүрдүүлэх зэрэгт чиглүүлэн тусалсны үр дүнд японы их дээд сургуулиудад урт болон богино хугацааны сургалтад тэтгэлэгтэй суралцах, гадаадын болон дотоодын байгууллагуудын тэтгэлэгт хөтөлбөрт амжилттай хамрагдах оюутны тоо өссөн байна. Тухайлбал сүүлийн 5 жилийн байдлаар нийт 17 оюутан япон судлалын салбарын тодорхойлолтоор Японд суралцаж бэлэн болон бэлэн бус байдлаар тэтгэлэгт хамрагдсан нь мэргэжлийн чиглэлийн зөвлөн туслах үйлчилгээний үр дүн гэж үзэж болохоор байна.
- Оюутан суралцагчдын судалгаа, шинжилгээний ажлыг удирдан чиглүүлж, эрдэм шинжилгээний хурал, мэргэжлийн олимпиадад оролцох, бакалаврын судалгааны ажил бичихэд заавар зөвлөгөө өгч, тайлангийн хугацаанд “Гадаад хэл, орон судлал (Япон)” хөтөлбөрийн 13 оюутан, өөрсдийн сонирхсон сэдвээр судалгаа хийж, оюутны эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн ба 2018 онд 1, 2019 онд 2, 2021 онд 9 оюутан бакалаврын судалгааны ажилд мэргэжлийн зөвлөн туслах үйлчилгээг үзүүлжээ.

#### **Анхаарах асуудал:**

- Суралцагчдаас зөвлөн туслах үйлчилгээний талаар сэтгэл ханамжийн судалгаа авч сайжруулахад анхаарах

#### **5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургуулийн хэмжээнд 45, салбар сургуулийн 13 клуб байнгын идэвхтэй үйл ажиллагаа явуулж, оюутнуудыг олон нийтийн үйл ажиллагаанд татан оролцуулах, дэмжих чиглэлээр ажиллаж байна.
- Сургалтаас гадуурх үйл ажиллагааны хувьд оюутны дунд эрдэм шинжилгээний хурал зохион байгуулахын зэрэгцээ олон төрлийн соёл, урлаг, спортын арга хэмжээ зохион явуулдаг, тэр дундаа мэргэжлийн чиглэлийн 4, улсын чанартай 10 уралдаан, олимпиад, мэргэжлийн чиглэлийн шалгалтыг зохион байгуулахад дэмжин ажилладаг уламжлал тогтсон нь хөтөлбөрийн оюутнуудын олон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог, хамтран ажилладаг болохын тод жишээ гэж үзэж болохоор байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн онцлогт тохирсон сургалтын болон олон нийтийн хосолсон хээрийн сургалт зохион байгуулдаг уламжлалтай.



- Оюутан, төгсөгчийн хэлтэс нь оюутнуудад хөдөлмөр эрхлэлтийн талаар лекц, семинар зохион байгуулах, зөвлөгөө өгөх, цагийн ажилд зуучлах, төгсөгчдийг ажлын байранд зуучлах, өдөрлөг хийх зэрэг үйл ажиллагаануудыг тогтмол удирдан зохион байгуулдаг. Улсын хөдөлмөрийн төв бирж, Нийслэлийн хөдөлмөрийн газар, МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд хамтран МУИС-ийн төгсөгчдийг ажлын байртай болгох, ажил олгогч аж ахуйн нэгж байгууллагуудад МУИС-ийн төгсөгчдөөс хүний нөөцөө бүрдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, оюутнуудын байнгын болон зуны амралтаар хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор “CAREER & JOB FAIR” өдөрлөгийг төлөвлөгөөний дагуу жил бүр зохион байгуулдаг уламжлал тогтжээ.
- Тус хөтөлбөрийн оюутнууд жил бүр МХАҮТ, Монгол-Япон төв, Монголд үйл ажиллагаа явуулж буй Японы аж ахуйн нэгж, хамтарсан компани зэрэг дотоодын байгууллагуудаас зохион байгуулдаг ажил олгогч, ажлын байр танилцуулах, хөдөлмөрийн зах зээлийн холбогдол бүхий үзэсгэлэн яармаг, өдөрлөг, уулзалт, форум, ярилцлагад санаачилгатайгаар хамрагдаж, мэдлэг, мэдээлэл авч оролцдог байна.

#### **Анхаарах асуудал:**

- Сургуулийн хэмжээнд 45, салбар сургуулийн 13 клубд суралцагчдын хамрагдалтыг нэмэгдүүлэх
- Мэргэжлийн болон улсын чанартай уралдаан, олимпиадад оролцох суралцагчдад үзүүлдэг дэмжлэг туслалцаа, түүний үр дүнг тооцоход анхаарах

#### **Зөвлөмж:**

- Суралцагчдад зориулсан аливаа зөвлөн туслах үйлчилгээний төлөвлөгөө, тайланд дүн шинжилгээ хийдэг болох
- Үр дүнг суралцагчдад чиглэсэн үйл ажиллагааг сайжруулахад ашиглах

#### **5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУИС-д суралцагч шилжүүлэн суралцуулах журам (2019 оны А/483 тоот тушаал).
- МУИС-д хичээл дүйцүүлэх журам (2019 оны А/495 тоот тушаал).
- “Гадаад хэл, орон судлал (Япон)” бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
- Суралцагчидтай хийсэн уулзалт

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- “МУИС-д суралцагч шилжүүлэн суралцуулах журам”-д дотоодын их, дээд сургуулиас шилжин суралцагчдад тавигдах шаардлага, МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжин суралцагчдад тавигдах шаардлага, шилжилтийн бүртгэл, шилжилтийн шалгалт, багц цаг дүйцүүлэн тооцох, шилжилттэй холбоотой зардал зэргийг нарийвчлан заасан байдаг.
- Шилжилт хөдөлгөөний жилд 2 удаа зохион байгуулж, <https://burtgel.num.edu.mn> бүртгэлийн нэгдсэн системд бүртгэдэг.
- “МУИС-д хичээл дүйцүүлэх журам”-д хичээл дүйцүүлэхэд баримтлах зарчим, багц цаг шилжүүлэн тооцох аргачлал, суралцагчийн үнэлгээ/дүнг тооцох аргачлал, гадаад хэлний шалгалтын оноог дүйцүүлэх, хичээл дүйцүүлэх үйл ажиллагаа зэргийг нарийвчлан тусгасан байдаг.
- МУИС-ийн хичээл дүйцүүлэлтийн үйл ажиллагааг дүн бүртгэл хариуцсан нэгж, суралцагч, мэргэжлийн тэнхимтэй хамтран зохион байгуулдаг.
- БШУЯ-наас 2021-10-06 өдөр “Дээд боловсролын зэрэг олгох сургалтад багц цагийг хэрэглэх, дүйцүүлэх, суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхэд баримтлах үлгэрчилсэн журам”-ыг батлан гаргасантай холбогдуулан, “МУИС-д хичээл дүйцүүлэх журам”-ыг шинэчлэн 2021-12-02 өдөр баталсан (2021 оны А/361 тоот тушаал).

#### **Анхаарах асуудал:**

- Хамтын ажиллагааны гэрээтэй Япон улсын сургуульд 1 жилийн хугацаатай суралцсан суралцагчийн судалсан хичээлийг дүйцүүлэхэд багц цагийн зөрүү гардаг. Тухайлбал, Япон улсын их сургуульд судалсан хичээлүүд нь ихэвчлэн 2 багц цаг байдаг бол тус хөтөлбөрийн судлах хичээлүүдийн багц цаг гол төлөв 3 байдаг. Тиймээс Японы их сургуульд судалсан 2 багц цагийн 2 хичээлийг тус хөтөлбөрийн 3 багц цаг бүхий 1 хичээлтэй дүйцүүлдэг.

#### **Зөвлөмж:**

- Хичээлийг дүйцүүлэхдээ багц цагийг харахаас гадна хичээлийн агуулга, суралцагчийн мэдлэг, чадварыг харгалзах боломжийг судлах

#### **5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

#### **Илрэл нотолгоо:**

- “МУИС-ийн сургалтын журам”-ын холбогдох заалтын дагуу төгсөлтийг зохион байгуулж, баримт бичгийг олгодог.
- Бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
- 2020 оны төгсөгчийн төгсөлтийн баримт бичгийн (дипломын) хуулбар

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Анхаарах асуудал:**

- Төгсөлтийн баримт бичигт судалсан хичээлийн багц цагийг сургалтын төлөвлөгөөнөөс зөрүүтэй тэмдэглэсэн. Тухайлбал, сургалтын төлөвлөгөөнд Чөлөөт сонголтын хэсгийн нийт багц цаг 15 бол төгсөлтийн баримт бичигт 9 багц цагаар тэмдэглэсэн.

#### **Зөвлөмж:**

- Сургалтын төлөвлөгөөнд тусгасан багц цагийн дагуу төгсөлтийн бичиг баримтад тэмдэглэгээ хийх

### **5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа**

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

##### **6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого**

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- “МУИС-д профессор, багш ажиллуулах журам” (2019)-ын дагуу багшийг сонгон шалгаруулалтаар авдаг. Сонгон шалгаруулалтыг 10 үе шаттай зохион байгуулдаг.
- Бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
- Багш нартай хийсэн уулзалт

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багшийг багшид тавих шаардлага хангасан хүнийг сонгон шалгаруулалтаар болон Өндөр мэргэшлийн эрдэмтнийг сонгон шалгаруулалтгүйгээр авч ажиллуулах гэсэн 2 хэлбэрээр авч ажиллуулдаг
- Сүүлийн 5 жилийн дунджаар багш нарын цагийн ачаалал 19% (2.8 кр) -хэвийн
- Үндсэн 11 багшийн 64% нь докторын зэрэгтэй, багшлах бүрэлдэхүүн тогтвортой.
- Докторантын хөтөлбөрт суралцаж буй багшийн тоо - 4 байна.
- Хөтөлбөрийн багш нарын албан тушаалын зэрэглэл: 2 багш профессор, 4 багш дэд профессор, 5 багш ахлах багш албан тушаалын зэрэглэлд ажиллаж байна. Бүх багш 20 гаруй жил ажилласан туршлагатай.
- Багш оюутны харьцаа 1:15-16

#### **Анхаарах асуудал:**

- “МУИС-д профессор, багш ажиллуулах журам”-ын 2.5: заалт нь “Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тавигдах нийтлэг шаардлага” (БСШУСЯ, 2020)-ын 2.6 дахь заалт буюу “Судалгаа, эрдэм шинжилгээний чиглэлээр салбарын хөгжилд хувь нэмэр

оруулж, инновац бүтээх үйлийг хийдэг байна.”, 3.4.4 дахь заалт “[Ахлах багш нь] дадлагажигч багш болон багшийн зэрэглэлд байх судалгаа, инновацийн шаардлагыг зохих түвшинд хэрэгжүүлэх” зэрэг заалттай нийцэхгүй байна.

**Зөвлөмж:**

- “МУИС-д профессор, багш ажиллуулах журам”-ыг “Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тавигдах нийтлэг шаардлага”-тай нийцүүлэх.

## **6.2. Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

**Илрэл нотолгоо:**

- “МУИС-ийн Багшийн хөгжлийн хөтөлбөр (2019-2024)” -бодлогын баримт бичгийг 2019-02-04 өдөр батлан гаргасан.
- Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд МУИС-ийн Багшийн хөгжил, цахим сургалтын төв (БХЦСТ) голлох үүрэг гүйцэтгэж, сургалт, хөтөлбөрийг тогтмол зохион байгуулдаг.
- Бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
- Багш нартай хийсэн уулзалт
- Багшийн хавтас

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн багш нар заах арга зүй, судалгааны арга зүй чиглэлээр гадаад, дотоодын мэргэжил дээшлүүлэх сургалтад тогтмол хамрагддаг.
- Сүүлийн 5 жилд Монголын Япон хэлний багш нарын холбоотой хамтран Япон хэлний боловсролын симпозиумыг хамтран зохион байгуулсан.

**Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн багш нарын суралцах хэрэгцээний судалгаа, тайлан байхгүй.

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн багш нарын суралцах хэрэгцээний судалгааг гаргаж, мөрдөх

## **6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

**Илрэл нотолгоо:**

- “МУИС-ийн судалгааны санхүүжилтийн журам”-ын хүрээнд сүүлийн 5 жилд 7 багш 32 сая төгрөгийн суурь судалгааны зардал авсан.

- “Багш, ажилтныг дэмжих зардал”-ын хүрээнд сүүлийн 5 жилд бүх багш санхүүжилт авсан. Нийт 18.9 сая санхүүжилтийн 67.2% нь судалгааны зардалд зарцуулсан.
- Япон сан, МУИС-ийн санхүүжилттэй Залуу судлаачдын багийн грант, гадаадын их сургуулийн зэрэг санхүүжилттэй Сурах бичиг боловсруулах, судалгааны, захиалгат төсөл, гэрээт ажил гүйцэтгэсэн.
- Бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
- Багш нартай хийсэн уулзалт
- Багшийн хавтас
- Багш нарын бүтээл

### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

#### Онцлог зүйл/Туршлага:

- Нийт суурь судалгааны зардлын 39.3%-ном, сурах бичиг, гарын авлага хэвлүүлэхэд; 7.8%-Гадаадын ЭШ сэтгүүлд хэвлүүлэхэд тус тус зарцуулсан.
- Нийт 51 өгүүлэл хэвлүүлснээс гадаадын сэтгүүлд 17, дотоодын сэтгүүлд 34 өгүүлэл хэвлүүлсэн.
- 2021 онд WoS-т бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл нэг байна.
- Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлэхээр 1 өгүүллийг засан сайжруулж байгаа.
- Сүүлийн 5 жилд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар гадаадын санхүүжилттэй 6 төсөл, дотоодын санхүүжилттэй 6 төсөл, гадаадын санхүүжилтэй гэрээт ажил 3 нийт 13 төсөл, гэрээт ажилд удирдагч болон гишүүнээр ажилласан.

#### Анхаарах асуудал:

- 4 багш МУИС-д 19-26 жил ажиллаж байгаа боловч “Ахлах багш” албан тушаалын зэрэглэлд ажиллаж байна. Үүнээс 3 багш 2018-2019, 2019-2020, 1 багш 2017-2018, 2018-2019 жилүүдэд зөвхөн сургалтын цаг биелүүлэх нөхцөлөөр ажилласан.
- 2015-2021 онд хэвлүүлсэн нийт 26 бүтээлийн (14 сурах бичиг, ном гарын авлага; 12 нэг сэдэвт бүтээл) зөвхөн 3 нь зохиогчийн эрхийн гэрчилгээтэй.

#### Зөвлөмж:

- WoS, Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, “Азийн шилдэг 100 их сургуулийн эгнээнд багтах” алсын харааг хэрэгжүүлэхэд хөтөлбөрийн багш нарын хувь нэмрийг нэмэгдүүлэх
- Бүтээлд зохиогчийн эрхийн гэрчилгээ авах

#### 6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

#### Илрэл нотолгоо:

- “МУИС-д профессор, багш ажиллуулах журам”-ын (9.4 дэх заалт) дагуу хичээлийн жилийн төгсгөлд багшийн өөрийн үнэлгээг А (сургалт), Б (эрдэм шинжилгээ), В (бусад ажил) багц цагийн гүйцэтгэлээр хийдэг.
- Оюутны сэтгэл ханамжийн үнэлгээ МУИС-ийн дунджаас дээгүүр үзүүлэлттэй.
- Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
- Багш нартай хийсэн уулзалт

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Бүрэлдэхүүн/салбар сургуулиуд сүүлийн 5 жилд профессор багшийн гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлын үзүүлэлтийг гол шалгуур болгон хичээлийн жилийн эцэст дараагийн 3 жилд ажиллах багш нарын албан тушаалын зэрэглэлийг тогтоодог.

#### **Анхаарах асуудал:**

- Зөвхөн сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэлээс тооцуулж, нормоос давсан гүйцэтгэлд илүү цагийн хөлс, жил бүрийн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний үр дүнд үндсэн цалингийн 60% орчим хэмжээгээр урамшуулал тус тус авсан.
- Харин эрдэм шинжилгээний ажилд урамшуулал аваагүй. Б.1.1 заалт (Web of Science IF-JCR импакт фактор индекс бүхий мэргэжлийн сэтгүүл: тухайн судалгааны салбарын дундаж индекс тэнцүү болон түүнээс дээгүүр индекс тэй ЭШ-ний сэтгүүлд хэлүүлсэн өгүүлэлд – 10 багц цаг тооцох)-ыг хэрэгжүүлэхэд анхаарах

#### **Зөвлөмж:**

- “Ахлах багш” албан тушаалын зэрэглэлд ажилладаг багш нарын эрдэм шинжилгээний ажил хийхийг сэдэлжүүлэх, докторын ажлыг эрчимжүүлэх

**6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

#### **7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургалтын үйл ажиллагааг шинжлэн дүгнэх сургалтын чанарын баталгаажуулалтын тогтолцоо
- Хөтөлбөрийн хороодын зохион байгуулалт, хуралдааны тэмдэглэлүүд
- Хөтөлбөрийн оролцогч талуудын оролцооны зураглал

- Төгсөгчид, ажил олгогчдоос авсан сэтгэл ханамж, санал асуулгын судалгаа

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтыг хариуцсан нэгж 2017 оноос Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын алба нэртэйгээр, 2018 оноос Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс нэртэйгээр үйл ажиллагаа явуулж, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажилладаг.
- Сургалтын үйл ажиллагааг шинжлэн дүгнэх сургалтын чанарын тогтолцооны зураглалыг тодорхой гаргасан.
- Хөтөлбөрт оролцогч зарим талаас сэтгэл ханамжийн судалгаа авч, боловсруулалт хийсэн.
- Төгсөгчдийн судалгаанаас харахад дийлэнх нь төгсөөд жилийн дотор ажилд орсон бөгөөд тухайн ажлын байраа өөрийн мэдлэг, ур чадвар, зөв хандлага, төлөвшлийн дүнд болон байгууллагаас тавьсан саналыг хүлээн авах байдлаар олсныг онцолсон байна. Тэд “Гадаад хэлний орчуулга (Япон хэл)” сургалтын хөтөлбөрийн талаар 26,2 хувь нь маш сайн, 54,8 хувь нь сайн, 14,3 хувь нь дунд гэсэн ерөнхий үнэлгээ өгчээ. Хөтөлбөрийн давуу талын талаар багшлах бүрэлдэхүүн, тэдний заах арга зүй, түүнтэй уялдаатай сургалтын чанарыг хэвээр хадгалах нь маш чухал гэж үзсэн байна.
- Суралцагчдын 71,4 хувь нь заавал судлах хичээлийн агуулга, уялдаа холбоог зарим талаар хангалттай гэж үзсэн бол 57,1 хувь нь сонгон судлах хичээлийн агуулга, уялдаа холбоог зарим талаар хангалттай гэж үзжээ. Оюутнуудад хичээл сонголт хийх, үргэлжлүүлэн суралцах боломжийн талаар зөвлөгөө өгөх байдлыг 35,7 хувь нь зарим талаар хангалттай, 28,6 хувь нь дунд зэрэг, оюутнуудад ирээдүйн карьер, ажил эрхлэлтийн талаар зөвлөгөө өгөх байдлыг 21,4 хувь нь зарим талаар 33,3 хувь нь дунд зэрэг гэж үнэлжээ.

### Анхаарах асуудал:

- Төгсөгч, ажил олгогчоос авах судалгаа тогтмолжоогүй.
- Хөндлөнгийн үнэлгээ, дүгнэлт төдийлөн хийгдээгүй.

### Зөвлөмж:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч баг төгсөгчидтэйгээ эргэх холбоотой байж, 5 жил тутамд эрэлт хэрэгцээг тандан судалж, хөтөлбөрийн хөгжүүлэлт хийж хэвших
- Хэрэгжүүлж буй хөтөлбөрөө ижил түвшний бусад сургуулиудын сургалтын хөтөлбөртэй харьцуулан судалж, давуу болон сул талаа олж харах
- Хөтөлбөрт хөндлөнгийн хяналт үнэлгээ хийх ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх

## **7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн үнэлгээний судалгаа
- Төгсөгчдийн ахисан түвшний сургалтад суралцаж буй байдал
- Хөтөлбөрөөр суралцаж төгссөн 4 судлаач Япон улсын хамтын ажиллагаатай их сургуульд суралцсан байна.
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа
- Төгсөгчдийн 90,9 хувь нь төгссөнөөс хойш 1-6 сарын дотор ажилд орсон байна.
- Төгсөгчдийн хөтөлбөрийн талаарх ерөнхий үнэлгээ
- Төгсөгчдөд тавигдах дадал, ур чадвар
- Төгсөгчдийн мэдлэг, ур чадварын үнэлгээ
- Суралцагчийн сэтгэл ханамжийн судалгаа

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Төгсөгчдийн тоон мэдээлэл, ахисан түвшний сургалтад суралцаж буй дүн, ажил эрхлэлтийн судалгааг гаргасан.
- Төгсөгчдийн хөтөлбөрийн талаарх үнэлгээ, түүний үр дүнгээс тусгасан.
- Төгсөгчдөд тавигдах дадал, ур чадвар, мэдлэг, ур чадварын үнэлгээг, тухайлбал, ажил олгогчийн зүгээс төгсөгчийн багаар ажиллах, хариуцлага хүлээх, төлөвлөх ур чадварыг 75 хувь, үзэл бодлоо өөртөө итгэлтэй илэрхийлэх ур чадварыг 61 хувь нь сэтгэл маш ханамжтай гэж үнэлжээ.

#### **Анхаарах асуудал:**

- Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгааг он оноор гаргах
- Төгсөгч, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авах, судалгааны асуулгад сургалтын төлөвлөгөөн дэх хичээлийн тоо, харьцаа, нэр нэршил, хөтөлбөрийн агуулгатай холбоотой асуулт оруулах

#### **Зөвлөмж:**

- Удирдлага, мэдээллийн системийг хяналт үнэлгээнд түлхүү ашиглах
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхимийн төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг идэвхжүүлж, хамтран ажиллах, тэдний ажил эрхлэлтийг тандан судалж, хөтөлбөрийн хөгжүүлэлтэд тусгах
- Төгсөгчдийн эрэлт хэрэгцээг тандах судалгааг тогтмол авч, судалгааны үр дүнг хөтөлбөрийн шинэчлэлтэй холбох



### **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- 2013 оны магадлан итгэмжлэлийн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ
- Төгсөгчдийн япон хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалтын дундаас дээш түвшин болох N3-N1 түвшинд тэнцсэн сертификатууд
- Төгсөгчид болон тэдний шавь нарын дотоод, гадаадын уралдаан, тэмцээнд оролцож, амжилт үзүүлсэн тоон мэдээлэл
- Ижил түвшний их, дээд сургуулийн япон хэлний сургалтын хөтөлбөрт зөвлөмж өгсөн байдал
- ЕБС болон бусад их, дээд сургуулийн япон хэлний багш нарт сургалт семинар явуулсан байдал

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Дотоод, гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн тоо, хувийг гаргасан.
- Япон хэлний сургалттай сургууль, Японд дадлагажигч ажилчин илгээх компани, хэлний сургалтын төв олширсон тул уг хөтөлбөр нь хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээ ихтэй, нийгэм, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн.

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрснийг нотлох баримт бичгийн судалгаа хангалттай бус.
- Хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийгдээгүй.

#### **Зөвлөмж:**

- Мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх
- Үндэсний болон олон улсын байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэх
- Хөтөлбөрийн нэр хүнд үнэлэмжийн судалгааг авч, он оноор ахиц өөрчлөлтийг илрүүлэх
- Хөтөлбөрийн танилцуулга, сурталчилгааг олон төрөл, хэлбэрээр хийх

## ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан/хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3			
2	Сургалтын үйл ажиллагаа	2	1		Сургалтын төлөвлөгөөний бүтцийг Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагын дагуу боловсруулан заавал судлах хичээлийг тусган төлөвлөх
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	3			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5			
5	Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	5			
6	Багшийн үйл ажиллагаа	4			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	3			
Дүгнэлт		<b>БҮРЭН ХАНГАСАН</b>			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын “Гадаад хэлний орчуулга (Япон)” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Урлаг, хүмүүнлэгийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

## НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

<b>Сургуулийн нэр</b>	Монгол улсын их сургуулийн Шинжлэх ухааны сургууль School of Arts and Sciences, National University of Mongolia /NUM/
<b>Хөтөлбөрийн нэр</b>	Гадаад хэлний орчуулга (япон)
<b>Хөтөлбөрийн индекс</b>	D023101
<b>Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт</b>	Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүдэд оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулах
<b>Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа</b>	Сургалтын арга зүйг суралцагчдын бие даасан суралцахуйг дэмжихэд чиглүүлэн сурлагын ахиц, амжилтад судалгаа хийж хөтөлбөрийг сайжруулах
<b>Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц</b>	Төгсөгчидтэй хамтран ажиллах эргэх холбоог сайжруулах, Цахим хичээл боловсруулах ажлыг эрчимжүүлж, сургалтад нэвтрүүлэхэд анхаарах
<b>Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт</b>	Солилцооны болон тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах багш суралцагчдын тоог нэмэгдүүлэх, Төгсөгчдийн холбоог албан ёсоор байгуулах, төгсөгчдийг давтан сургахад анхаарах, Хөтөлбөрийн сайжруулалтад зориулсан төсөв, төсвийн зарцуулалтын үр ашгийг тооцох Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс олон нийтэд чиглэсэн сонин, сэтгүүл, ном товхимол гарын авлагын тоо, цахим мэдээллийг сайжруулан тогтмол хүргэх
<b>Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ</b>	Суралцагчдад зориулсан аливаа зөвлөн туслах үйлчилгээний төлөвлөгөө, тайланд дүн шинжилгээ хийдэг болох Сургалтын төлөвлөгөөнд тусгасан багц цагийн дагуу төгсөлтийн бичиг баримтад тэмдэглэгээ хийх
<b>Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа</b>	МУИС-д профессор, багш ажиллуулах журам"-ыг "Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тавигдах нийтлэг шаардлага"-тай нийцүүлэх Хөтөлбөрийн багш нарын суралцах хэрэгцээний судалгааг гаргаж, мөрдөх Хөтөлбөрийн багш нарын WoS, Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, хувийг нэмэгдүүлэх Бүтээлд зохиогчийн эрхийн гэрчилгээ авах "Ахлах багш" албан тушаалын зэрэглэлд ажилладаг багш нарын эрдэм шинжилгээний ажил хийхийг сэдэлжүүлэх, докторын ажлыг эрчимжүүлэх
<b>Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт</b>	Сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд шинжилгээ хийж, үйл ажиллагаандаа тусгах Удирдлага, мэдээллийн системийг хяналт үнэлгээнд түлхүү ашиглах Төгсөгчдийн эрэлт хэрэгцээг тандах судалгааг тогтмол авч, судалгааны үр дүнг хөтөлбөрийн шинэчлэлтэй холбох Мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх
<b>ШААРДЛАГА: /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал шаардлага бичнэ/</b>	
<b>Шалгуур 2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл</b>	<ul style="list-style-type: none"> <li>Сургалтын хөтөлбөрийн бүтэц, харьцааг БСШУЯ-ны сайдын 2014 оны А/174 тоот тушаалд нийцүүлж, "Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага"-ыг хэрэгжүүлэх</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>• Ерөнхий суурь хичээл (А), Мэргэжлийн суурь хичээл (Б), Мэргэжлийн хичээл (В)-ийг тус бүрт нь заавал болон сонгон судлах хичээл гэсэн 2 хэсэгтэйгээр төлөвлөх</li> <li>• Ерөнхий суурь хичээл (А) хэсэгт судлагдахууны чиглэлийг бус, хичээлийн нэрийг тодорхой тусгах</li> <li>• Гамшгаас хамгаалах менежментийн үндэс хичээлийг Ерөнхий суурь хичээл (А)-ийн заавал судлах хичээлд багтаах</li> <li>• Мэргэжлийн суурь хичээл (Б), Мэргэжлийн хичээл (В) хэсгийн бүх хичээл 3 багц цаг байгааг өөрчилж, хичээлийн агуулга, арга зүй, үнэлгээ, жин, багтаамжид нийцүүлэн, ялгамжтай болгох</li> <li>• Хөтөлбөрийн үр дүн болон хичээлийн үр дүнгийн хамаарлыг PLO-CLO-хичээл гэсэн байдлаар матриц гаргаж, шинжилгээ хийх</li> <li>• Хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын саналд үндэслэж, мэргэжлийн хичээлүүдэд өөрчлөлт оруулах</li> <li>• А/103, А/285 болон А/262 тоот тушаалын хэрэгжүүлэх</li> </ul>
--	---

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг: ..... У.Мягмаржав

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг: ..... Б.Булган

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг: ..... С.Батдулам

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг: ..... Б.Батсайхан

#### IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

##### I. Багш нарын нэрс

№	Овог нэр	Албан тушаал	Заадаг хичээл	Ажилла сан жил	Эрдмийн зэрэг цол
1	П.Энхжаргал	профессор	Япон хэл шинжлэлийн удиртгал Дунд шатны япон хэлний хэлзүй 1 Дунд шатны япон хэлний хэлзүй 2	19	Док /Ph.D/
2	Ц.Онон	профессор	Сонгодог уран зохиол Япон хэл, соёл Дээд шатны унших дадал Дунд шатны унших бичих дадал 1	16	Док /Ph.D/
3	Ц.Дэлгэрэхцэцэг	дэд профессор	Япон хэлний анхан шатны хэлзүй Дээд шатны бичгийн хэл Япон хэлний утгазүй	27	Док /Ph.D/
4	Д.Майсүлд	дэд профессор	Япон хэлний дунд шатны хэлзүй 2 Японы улс төр, гадаад харилцаа Япон хэлний бичгийн орчуулга	14	Док /Ph.D/
5	Т.Болдбаатар	ахлах багш	Дээд шатны ярих дадал Дунд шатны ярих сонсох дадал1 Японы уран зохиолын удиртгал Япон хэлний хэлмэрчлэхүй	26	Магистр
6	Э.Батжаргал	ахлах багш	Анхан шатны япон хэлний унших бичих дадал Эдийн засгийн газарзүй Ерөнхий суурь Япон хэл 1	26	Магистр
7	Б.Хишигдэлгэр	ахлах багш	Анхан шатны япон хэлний ярих сонсох дадал Дээд шатны япон хэлний унших дадал Япон хэлний нийгэм улс төрийн орчуулга	18	Док /Ph.D/
8	Э.Тогтуун	ахлах багш	Японы соёл урлаг Дунд шатны япон хэлний унших бичих дадал 2 Ерөнхий суурь Япон хэл 1,2	26	Магистр
9	Б.Боргилмаа	ахлах багш	Япон хэлний ярих сонсох дадал	19	Магистр
10	Н.Бадрал	Ахлах багш	Япон хэл 1, 2	15	Док /Ph.D/

## II. Оюутны нэрс

№	Овог нэр	Курс	Сонгосон байдал	Утасны дугаар
1	Батцэнгэл Буянзаяа	2	Япон хэлний орчуулга	80402226
2	Баттуяа Даваадулам	2	Япон орон судлал	88274779
3	Цогбадрах Сумьяажав	2	Япон орон судлал	80195784
4	Соёл-Эрдэнэ Уянга	2	Япон орон судлал	95481616
5	Энхбат Ууганзаяа	2	Япон хэлний орчуулга	85752217
6	Одмаа Хишгээ	2	Япон орон судлал Оюутны байранд амьдардаг	95257634
7	Ганхуяг Шинэбаяр	2	Япон хэлний орчуулга	90101678
8	Отгондаваа Анударь	2	Япон орон судлал	96899169
9	Батбаяр Ариунзаяа	2	Япон орон судлал	99599264
10	Мөнхбат Мөнх Алдар	2	Япон хэлний орчуулга Оюутны байранд амьдардаг	80487475
11	Даваа Бадмаараг	3	МУИС-ийн тэтгэлэг авсан	99175144
12	Баянзул Чинтүшиг	3	Япон орон судлал	94099027
13	Хишигдүүрэн Нандин-Учрал	3	Япон орон судлал	99151385
14	Энхжаргал Сономдолгор	3	Япон орон судлал	99995864
15	Энхбаатар Мөнхгэрэл	3	Япон орон судлал	99224108
16	Одонбаяр Бат-Эрдэнэ	3	Япон орон судлал	86310121
17	Лхагваа Нармандах	3	Япон орон судлал	95334855
18	Цогбаяр Маралгоо	3	Япон орон судлал	95510577
19	Батсүх Ивээл	4	Япон орон судлал	91306976

20	Баттогтох Ану	4	Япон хэл орчуулга	93432552
21	Ганбат Мөнхтуул	4	Япон хэл орчуулга "Intro" ярианы клуб	99408528
22	Оюунбаатар Алтантогос	4	Япон хэл орчуулга	88811480
23	Мөнхбаатар Хандаа	4	Япон орон судлал тэтгэлэгт хамрагдаж байсан	95211063
24	Мөнхсайхан Мөнххүслэн	4	Япон орон судлал	80850858
25	Гантөр Хонгорзул	4	Япон орон судлал	99222016
26	Отгон Мөнхжин	4	Япон орон судлал	99024272
27	Баяраа Бат-Оргил	4	Япон орон судлал	95963965
28	Амарсанаа Сумъяадорж	4	Тэтгэлгээр японд суралцсан	94448480
29	Дорждэрэм Чоймаамарал	4	"Intro" ярианы клуб	99612101

### III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэр /мэйл хаяг	Албан тушаал	Байгууллага	Утасны дугаар
1	Д.Отгонбаатар <a href="mailto:onbr88@gmail.com">onbr88@gmail.com</a>	Захирал	Шинэ гарц төв ТББ	88668836
2	М.Доржханд <a href="mailto:mishigdorjkhand@gmail.com">mishigdorjkhand@gmail.com</a>	Захирал	Жигүүр ХХК	99115976
3	Т.Косэ <a href="mailto:kose.t@unigas.mn">kose.t@unigas.mn</a>	Гүйцэтгэх захирал	Юнигаз ХХК	94014028
4	М.Сэргэлэн <a href="mailto:m.sergelen@gmail.com">m.sergelen@gmail.com</a>	Захирал	Монгол Коосэн	99110823
5	Б.Эрдэнэцэцэг <a href="mailto:newsapporo8888@yahoo.co.jp">newsapporo8888@yahoo.co.jp</a>	Захирал	Нью Саппоро ХХК	99112947
6	Д.Цацрал <a href="mailto:dtsatsral0809@gmail.com">dtsatsral0809@gmail.com</a>	Япон хэлний сургалт хариуцагч	Южи Энержи ХХК Васаби сургалтын төв	99115662
7	Д.Даваадорж <a href="mailto:davka75@gmail.com">davka75@gmail.com</a>	Захирал	НИ-МО консалтинг ХХК	95335151
8	Ч. Бямбадорж <a href="mailto:Chinbat.byambadorj99@gmail.com">Chinbat.byambadorj99@gmail.com</a>	Удирдагч Япон хэлний багш, менежер	Эртэч монгол ТТБ Хаши ХХК, Хаши сургалтын төв	89946980
9	П.Төмөр-Очир <a href="mailto:arig2004@yahoo.com">arig2004@yahoo.com</a>	Захирал	Азийн хүлэг ХХК	99118653
10	О.Бүжин <a href="mailto:Ob_anu@yahoo.com">Ob_anu@yahoo.com</a>	Монгол дахь гүйцэтгэх захирал	Ториган ХХК	91040722
11	Т. Оюундалай <a href="mailto:oyunaat950@gmail.com">oyunaat950@gmail.com</a>	Монгол дахь гүйцэтгэх захирал	Инами Медикал ХХК	99174724

12	Ц.Гантулга <a href="mailto:tserendorjgantulga.mg@jica.go.jp">tserendorjgantulga.mg@jica.go.jp</a>	Монгол дахь Төлөөлөгчийн газрын сайн дурын гишүүдийн асуудал болон төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн	ЖАЙКА ОУБ	11-325939 99212338
13	Б.Ундрахбаяр <a href="mailto:undrakhbayarc@gmail.com">undrakhbayarc@gmail.com</a>	Удирдах зөвлөлийн гишүүн Хөдөлмөр нийгмийн бодлогын зөвлөх	Түгээмэл хөгжил ТТБ Ерөнхий сайдын ажлын алба	99856665
14	Ц.Сувдаа <a href="mailto:suvdhuu@noyонуул.mn">suvdhuu@noyонуул.mn</a>	Гадаад албаны дарга	Ноён Уул Эрдэнэ ХХК	91040202
15	Л.Хоролмаа Horolmaa_0331@yahoo.com	Нарийн бичгийн дарга	Батширээт сумын ИТХ	93219829

#### IV. Төгсөгчдийн нэрс

Но	Овог, нэр	Утасны дугаар	Мэйл хаяг	Мэргэжлээр ажиллаж буй эсэх	Ажиллаж буй байгууллага
1	Гансүрэн Бат- Эгшиглэн	98648040	batka94322060@ gmail.com	тийм	Хэнтий, Батширээт сумын ИТХ, мэргэжилтэн
2	Энхбаатар Энхжаргал	89190744		тийм	Монгол Коосэн, багш
3	Мөнхсайхан Даваадорж	88595994	Ainii.davaa@gmail .com	тийм	Монголын оюун ухааны Академи, ажилтан
4	Зоригт Одгэрэл	99619065		тийм	Нитэничи ХХК, орчуулагч
5	Тулга Ангирмаа	80330101	angirmaat@gmail. com	үгүй	Өөр мэргэжлээр үргэлжлүүлэн сурч байгаа
6	Батбаяр Оюунтунгалаг	99735515	oyuntungalag310 @gmail.com	тийм	Монгол Коосэн, Гадаад харилцаа Карьер төвийн ажилтан
7	Энхболд Тэргэл	99142823	tergele@gmail.co m	тийм	МУИС, АСТ-ийн магистрант



8	Хүрэлбаатар Төгөлдөр	88851846	xtuuguux123@gmail.com	үгүй	SBT ХХК, ажилтан
9	Булган Ариунзул	94044028	zulaakaa11@gmail.com	тийм	ЮниГаз ХХК, Захиргаа хүний нөөцийн албанд ажилладаг
10	Түмэн-Өлзий Жавзанпагма	98988110	jawzaa.utis@gmail.com	тийм	Монголын Үндэсний Техникийн Их Сургууль, Сургалтын албанд мэргэжилтэн
11	Болор-Эрдэнэ Номингэрэл	88041680	Nomingerel893@gmail.com	тийм	Дорноговь Сайншанд 5-р сургууль, багш
12	Ууганбаяр Гомбосүрэн	89911180	Gombosuren0625@gmail.com	тийм	Жайка ОУ-ын байгууллагад орчуулагч
13	Бадрах Норовсүрэн	93003366	bnorovsuren@yahoo.com	тийм	Магистрт үргэлжлүүлэн сурч байгаа
14	Пүрэв Ариунзул	99620780	Ariunzul038@gmail.com		Зэс эрдэнэ уул уурхайн компани, хүний нөөцийн ажилтан
15	Чинбат Бямбадо рж	89946990	Chinbat.byambadorj99@gmail.com	тийм	Hashi education center Боловсролын төвд захирал
16	Ганзориг Туул	89995712	Tuul.g@logarithm.edu.mn	тийм	Логарифм сургууль Багш
17	Ганбат Мөрөн	99295583	yukiatsu@gmail.com	тийм	Шинэ гарц төв, багш
18	Азат Арайлам	99585637	azatarailam@gmail.com	үгүй	ХХБ, харилцагчийн хэлтэст ажилладаг
19	Жавхлан Эрдэнэ	88376886	erdenejavkhlan11@gmail.com	тийм	Newline сургалтын төв, багш

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) ..... [Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо) .....  
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/